


ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-03 САР)

Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2015 оны 3 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4408 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 3 дугаар сарын байдлаар орон сууцны үнэ өмнөх сараас 0.1%-иар өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 6.7%, сүүлийн 8 сард 6.2%-иар буурчээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



2015 оны 3 дугаар сард зах зээл дээрх орон сууцны үнэ харьцангуй тогтворжих хандлагатай болсон бөгөөд тухайн сард өндөр өртөг бүхий шинэ орон сууц нийлүүлэгдсэнтэй холбоотойгоор орон сууцны үнэ өмнөх сараас бага зэрэг өндөр гарчээ.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэх орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-д хүрчээ. Харин 2014 оны 4 дүгээр сараас эхлэн өсөлтийн хурд саарч, улмаар сүүлийн 4 сарын туршид орон сууцны үнэ жилийн өмнөхөөс буурсан байна.

Жишээ: “Богд ар” хороололд 2014 оны 7 дугаар сард 1 м² дундаж үнэ 1,939,575 төгрөг байсан бол 2015 оны 3 дугаар сарын байдлаар 1,819,588 төгрөг болж 6.2%-иар буурсан байна.


1. Шинэ орон сууцны үнэ¹

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 3 дугаар сарын байдлаар 2,171,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.8 хувиар буурсан дүнтэй байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.03/


Орон сууцны дундаж үнэ	2,171,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-4.8%
Сарын өсөлтийн хувь	0.6%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2015 оны 3 дугаар сарын байдлаар 96,028,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувиар буурсан дүнтэй байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.03/


Орон сууцны дундаж үнэ	96,028,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-5.8%
Сарын өсөлтийн хувь	0.1%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сая.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)

¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.